



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Ихтамир сумын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/092/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ
Утас: 99210906

Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 136

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ИХТАМИР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.МӨНХЗАЯА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Ихтамир сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээний хүрээнд орон нутгийн төсвөөс **254,731.6** мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэл 81.9 хувь буюу **208,581.2** мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 46,150.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 үндсэн зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын ИТХ-ын даргаас 85 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,400,000.00</u>	=
34	УРЬДЧИЛГАА	10,400,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	10,400,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>17,349,454.15</u>	<u>16,504,221.96</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,349,454.15	16,504,221.96
392	Биет хөрөнгө	17,349,454.15	16,504,221.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	11,639,112.00	11,639,112.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,011,284.23)	(6,951,136.19)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	12,729,800.00	16,449,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,751,423.55)	(5,447,703.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,380,359.00	3,129,363.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,637,109.07)	(2,315,113.11)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,348,000.00	1,348,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,348,000.00)	(1,348,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>27,749,454.15</u>	<u>16,504,221.96</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>25,715,354.15</u>	<u>14,470,121.96</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	25,715,354.15	14,470,121.96
512	Хуримтлагдсан үр дүн	25,339,286.15	14,094,053.96
51210	Өмнөх үеийн үр дүн	25,339,286.15	14,939,286.15
51220	Тайлант үеийн үр дүн	-	(845,232.19)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	376,068.00	376,068.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>25,715,354.15</u>	<u>14,470,121.96</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	268,804,700.00	220,963,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	268,804,700.00	220,963,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	268,804,700.00	219,963,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	268,804,700.00	219,963,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	259,654,448.85	221,808,932.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	259,654,448.85	221,808,932.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	156,473,342.90	195,479,202.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	116,549,957.13	151,389,947.36
210101	Үндсэн цалин	70,582,480.09	102,784,731.01
210102	Нэмэгдэл	45,967,477.04	44,919,216.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,170,000.00
210104	Урамшуулал	-	2,516,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,454,639.92	18,263,865.27

Архангай аймгийн Ихтамир сумын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	10,767,839.92	13,131,400.50
210202	Тэтгэмжийн даатгал	1,421,700.00	1,470,416.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,137,400.00	735,206.44
210204	Ажилгүйдлийн даатгал	284,300.00	555,435.49
210205	Эрүүл мэндийн даатгал	2,843,400.00	2,371,405.96
2104	Хангамж, бараа материалын зардал	8,359,450.00	7,731,300.00
210401	Бичиг хэрэг	823,300.00	1,072,700.00
210402	Тээвэр, шатахуун	6,797,970.00	6,130,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	238,180.00	479,800.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	48,000.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	800,000.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,422,747.00	12,068,957.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,422,747.00	12,068,957.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,186,548.85	5,225,132.19
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,118,900.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,067,648.85	4,725,132.19
2113	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,181,105.95	26,329,729.48
21132	Бусад урсгал шилжүүлэг	60,478,812.00	14,947,220.00
2113205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	12,870,000.00
2113207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,708,300.00	-
2113208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,771,512.00	-
2113209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,999,000.00	2,077,220.00
21134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	42,702,293.95	11,382,509.48
2113403	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,702,293.95	11,382,509.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>9,150,251.15</u>	<u>(845,232.19)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>9,150,251.15</u>	<u>(845,232.19)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>268,804,700.00</u>	<u>220,963,700.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>268,804,700.00</u>	<u>220,963,700.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	268,804,700.00	219,963,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	268,804,700.00	219,963,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>266,986,800.00</u>	<u>217,083,800.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>266,986,800.00</u>	<u>217,083,800.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>153,405,694.05</u>	<u>190,754,070.52</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	116,549,957.13	151,389,947.36
210101	Үндсэн цалин	70,582,480.09	102,784,731.01
210102	Нэмэгдэл	45,967,477.04	44,919,216.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,170,000.00
210104	Урамшуулал	-	2,516,000.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,454,639.92	18,263,865.27
210201	Тэтгэврийн даатгал	10,767,839.92	13,131,400.50
210202	Тэтгэмжийн даатгал	1,421,700.00	1,470,416.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,137,400.00	735,206.44
210204	Ажилгүйдлийн даатгал	284,300.00	555,435.49
210205	Эрүүл мэндийн даатгал	2,843,400.00	2,371,405.96
2104	Хангамж, бараа материалын зардал	8,359,450.00	7,731,300.00
210401	Бичиг хэрэг	823,300.00	1,072,700.00
210402	Тээвэр, шатахуун	6,797,970.00	6,130,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	238,180.00	479,800.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	48,000.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	800,000.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,422,747.00	12,068,957.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,422,747.00	12,068,957.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,118,900.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,118,900.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,581,105.95	26,329,729.48
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,400,000.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	10,400,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,478,812.00	14,947,220.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	12,870,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,708,300.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,771,512.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,999,000.00	2,077,220.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	42,702,293.95	11,382,509.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,702,293.95	11,382,509.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,817,900.00</u>	<u>3,879,900.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>1,817,900.00</u>	<u>3,879,900.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>1,817,900.00</u>	<u>3,879,900.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	1,817,900.00	3,879,900.00
223001	Бусад хөрөнгө	1,817,900.00	3,879,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,817,900.00)</u>	<u>(3,879,900.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,034,100.00	376,068.00	25,339,286.15	27,749,454.15
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(10,400,000.00)	(10,400,000.00)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,034,100.00	376,068.00	14,939,286.15	17,349,454.15
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(845,232.19)	(845,232.19)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,034,100.00	376,068.00	14,094,053.96	16,504,221.96
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,034,100.00	376,068.00	14,094,053.96	16,504,221.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(10,400,000.00)	(10,400,000.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,034,100.00	376,068.00	3,694,053.96	6,104,221.96
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(845,232.19)	(845,232.19)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,034,100.00	376,068.00	2,848,821.77	5,258,989.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	254,731,600.00	208,581,190.52	46,150,409.48	81.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	254,731,600.00	208,581,190.52	46,150,409.48	81.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	225,861,600.00	193,633,970.52	32,227,629.48	85.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	156,090,700.00	151,389,947.36	4,700,752.64	96.99
210101	Үндсэн цалин	156,090,700.00	102,784,731.01	53,305,968.99	65.85
210102	Нэмэгдэл	-	44,919,216.35	(44,919,216.35)	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,170,000.00	(1,170,000.00)	-
210104	Урамшуулал	-	2,516,000.00	(2,516,000.00)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,511,300.00	18,263,865.27	1,247,434.73	93.61
210201	Тэтгэврийн даатгал	13,267,600.00	13,131,400.50	136,199.50	98.97
210202	Тэтгэмжийн даатгал	1,560,900.00	1,470,416.88	90,483.12	94.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	780,500.00	735,206.44	45,293.56	94.20
210204	Ажилгүйдлийн даатгал	780,500.00	555,435.49	225,064.51	71.16
210205	Эрүүл мэндийн даатгал	3,121,800.00	2,371,405.96	750,394.04	75.96
2104	Хангамж, бараа материалын зардал	9,600,000.00	7,731,300.00	1,868,700.00	80.53
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,072,700.00	127,300.00	89.39
210402	Тээвэр, шатахуун	7,300,000.00	6,130,800.00	1,169,200.00	83.98
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	479,800.00	120,200.00	79.97
210404	Ном, хэвлэл	500,000.00	48,000.00	452,000.00	9.60

Архангай аймгийн Ихтамир сумын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,650,000.00	3,879,900.00	2,770,100.00	58.34
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,650,000.00	3,879,900.00	2,770,100.00	58.34
2107	Томилолт, зочны зардал	2,030,000.00	800,000.00	1,230,000.00	39.41
210702	Дотоод албан томилолт	2,030,000.00	800,000.00	1,230,000.00	39.41
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,979,600.00	11,068,957.89	17,910,642.11	38.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,979,600.00	11,068,957.89	17,910,642.11	38.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	500,000.00	2,500,000.00	16.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	500,000.00	2,500,000.00	16.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,870,000.00	14,947,220.00	13,922,780.00	51.77
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	13,500,000.00	-	13,500,000.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	13,500,000.00	-	13,500,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,370,000.00	14,947,220.00	422,780.00	97.25
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,870,000.00	12,870,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	2,077,220.00	422,780.00	83.09
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	254,731,600.00	208,581,190.52	46,150,409.48	81.88
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	254,731,600.00	208,581,190.52	46,150,409.48	81.88
132001	Орон нутгийн төсвөөс	254,731,600.00	208,581,190.52	46,150,409.48	81.88
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		(62,314.00)	62,314.00	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	3.00	3.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	1.00	1.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	3.00	3.00	-	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	2.00	2.00	-	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	1.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00

131104

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө

1,000,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулаагүй 200.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 200.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,474.7 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. Эд хөрөнгийн тооллоготой холбоотой

Илрүүлэлт: Тус байгууллага нь 2025 онд эхний хагас жилээр болон жилийн эцсийн байдлаар эд хөрөнгийн тооллогыг хуулиар заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 70.2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль журмын дагуу хөрөнгийг тооллогыг хийж, нотлох баримтаар эргэн хянуулах албан шаардлагыг хүргүүллээ.

3.1.2. Өмч хамгаалах зөвлөлтэй холбоотой:

Илрүүлэлт: Ихтамир сумын ИТХ нь өмч хамгаалах орон тооны бус зөвлөлийг байгуулаагүй, төлөвлөгөөг батлуулаагүй, үр дүнг тайлагнаж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", ТӨБЗГ-ын 2022.02.22-ны өдрийн 65 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-г зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох журмын дагуу өмч хамгаалах зөвлөлийг байгуулж, төлөвлөгөөг батлуулж, үр дүнг тайлагнаж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

3.2 Төлбөрийн акт

3.2.1. Түлээ нүүрсний хөнгөлөлттэй холбоотой:

Илрүүлэлт: Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2025.11.20-ны өдрийн 27 дугаар тушаалыг үндэслэн НБДарга Б.Мөнхзаяа нь өөртөө 200.0 мянган түлээ нүүрсний хөнгөлөлтийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсвийн орлогын дансанд буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Хөрөнгийг тооллогыг хийгээгүй	1				1				-				
Өмч хамгаалах зөвлөлийг байгуулаагүй, төлөвлөгөө, тайлангүй	1				1								
Өөртөө тушаал гарган түлээ нүүрсний хөнгөлөлт шилжүүлсэн	1	200.0	1	200.0									
Дүн	3	200.0	1	200.0	2								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.